



**ХЭНТИЙ АЙМГИЙН
НОРОВЛИН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 10 сарын 13 өдөр

Дугаар А/115

Жаргалант

Ажлын хэсэг томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Хэнтий аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.3.1.13, 2.1.4.2 дахь хэсэг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2024 оны 12 дугаар сарын 27-ний өдрийн ээлжит гуравдугаар хуралдааны 02 дугаар тогтоолоор батлагдсан “Норовлин сумын Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.2.1.8 дахь заалтыг тус тус үндэслэн тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Иргэдийн дунд эрүүл амьдралын хэв маягийг төлөвшүүлэх, эрүүл зөв хооллолт, хөдөлгөөний дутагдлыг бууруулах зорилгоор “Идэвхтэй хөдөлгөөн-Эрүүл Хэнтийчүүд” аяныг Норовлин суманд зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч	Д.Шижирмөнх	Засаг даргын орлогч
Нарийн бичиг	Г.Тэргэл	Нийгмийн бодлогын мэргэжилтэн
Гишүүдэд	Г.Хишигбаатар	Биеийн тамирын багш
	Г.Нямбар	Биеийн тамирын багш
	Ц.Жинжиймаа	ЕБС-ийн нийгмийн ажилтан
	Ю.Намуунзаяа	СӨБ-ийн биеийн тамирын багш
	М.Мөнхзул	ЭМТ-ийн нийгмийн ажилтан
	Б.Хулангоо	Бүжгийн багш
	Г.Анхзаяа	Хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан

2.“Идэвхтэй хөдөлгөөн-Эрүүл Хэнтийчүүд” аяныг Норовлин суманд зохион байгуулах ажлын төлөвлөгөөг 2025 оны 10 дугаар сарын 15-ны дотор боловсруулж танилцуулахыг ажлын хэсгийн нарийн бичиг (Г.Тэргэл)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ө.ДАВААЖАРГАЛ

D:bichig hereg /zahiramj-2025

232501281